

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/74/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjav.b@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>

Агуулга

1.Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

**ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ ЭМЧ
Н.МӨНХЗУЛ ТАНАА**

2021.02.25 № 2/аа
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Өмнөх онд санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн биелүүлээгүй, хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны зардлыг зориулалт бусаар зарцуулсан, шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаагүй, зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох эрхзүйн актуудтай нийцэхгүй, аудитын “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал”, “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

021020268

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Н.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,368,653.60	24,801,628.45
33	АВЛАГА	127,274.50	631,138.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	127,274.50	631,138.50
35	БАРАА МАТЕРИАЛ	18,241,379.10	24,170,489.95
351	Түүхий эд материал	3,414,088.00	10,328,921.05
35130	Эм боох материал	3,414,088.00	10,328,921.05
354	Хангамжийн материал	14,510,291.10	13,524,568.90
35410	Бичиг хэргийн материал	76,000.00	-
35420	Аж ахуйн материал	11,275,827.00	8,953,499.00
35430	Сэлбэг хэрэгсэл	35,000.00	-
35460	Хүнсний материал	3,123,464.10	1,824,569.90
35470	Бусад хангамжийн материал	-	2,746,500.00
35600	Мал амьтад	317,000.00	317,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	350,679,549.72	334,745,783.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	350,679,549.72	334,745,783.80
392	Биет хөрөнгө	336,599,549.72	319,415,783.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	298,751,305.00	299,474,305.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,159,968.43)	(24,757,526.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,398,656.00	41,398,656.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(16,424,525.70)	(23,050,968.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	78,166,351.00	84,966,351.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(64,617,362.20)	(69,918,228.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,009,149.92	39,874,149.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,524,055.87)	(28,570,954.63)
393	Биет бус хөрөнгө	14,080,000.00	15,330,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,080,000.00	14,080,000.00
39301	Програм хангамж		1,250,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	369,048,203.32	359,547,412.25
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	213,075.00	270,068.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	213,075.00	270,068.00
413	Өглөг	213,075.00	270,068.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	213,075.00	270,068.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	368,835,128.32	359,277,344.25
51	Засгийн газрын хувь оролцоо	368,835,128.32	359,277,344.25
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	201,605,647.02	201,605,647.02
51101	Өмч: - төрийн	201,605,647.02	201,605,647.02
512	Хуримтлагдсан үр дүн	66,814,589.06	57,256,804.99
51210	Өмнөх үеийн үр дүн	66,814,589.06	66,814,589.06
51220	Тайлант үеийн үр дүн	-	-9,557,784.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100,414,892.24	100,414,892.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	369,048,203.32	359,547,412.25

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	358,253,802.00	405,134,990.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,504,122.00	9,919,405.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,222,222.00	9,919,405.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,222,222.00	9,919,405.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,222,222.00	9,919,405.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	23,281,900.00	-
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	23,281,900.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	332,749,680.00	395,215,585.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	309,068,200.00	337,119,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	309,068,200.00	337,119,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,400.00	10,578,825.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,400.00	10,578,825.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	23,513,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		23,513,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	23,632,080.00	24,003,860.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,632,080.00	24,003,860.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	371,377,593.85	414,692,774.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	371,377,593.85	414,692,774.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,377,593.85	414,492,774.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,235,729.00	267,598,568.97
210101	Үндсэн цалин	227,235,729.00	189,447,907.97
210102	Нэмэгдэл	-	65,149,758.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,873,406.00
210104	Урамшуулал	-	9,127,497.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,982,530.00	33,698,573.03
210201	Тэтгэврийн даатгал	24,695,392.00	22,915,029.67
210202	Тэтгэмжийн даатгал	4,115,938.00	2,695,885.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,156,708.66
210204	Ажилгүйдлийн даатгал	-	539,177.18
210205	Эрүүл мэндийн даатгал	171,200.00	5,391,771.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,387,973.01	22,592,496.00
210301	Гэрэл, цахилгаан	1,590,310.00	1,878,452.00
210302	Түлш, халаалт	19,706,283.01	20,621,000.00
210303	Цэвэр, бохир ус	91,380.00	93,044.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,768,266.00	23,560,912.00
210401	Бичиг хэрэг	2,264,526.00	2,749,169.00
210402	Тээвэр, шатахуун	16,373,850.00	12,911,091.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,000.00	1,705,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	381,280.00	88,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,428,610.00	6,107,252.00
2105	Нормативт зардал	32,407,311.80	37,074,008.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,246,981.00	27,662,737.95
210502	Хоол, хүнс	5,160,330.80	9,411,270.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,625,450.00	2,400,400.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	1,469,800.00	2,175,400.00
210604	Урсгал засвар	1,155,650.00	225,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,223,000.00	600,000.00
210702	Дотоод албан томилолт	1,223,000.00	600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,659,572.40	932,050.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,232,572.40	350,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	179,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	183,050.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	248,000.00	144,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,087,761.64	26,035,765.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	702,500.00	464,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,385,261.64	25,571,765.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(13,123,791.85)	-9,557,784.07
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(13,123,791.85)	-9,557,784.07

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	356,031,580.00	395,215,585.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	356,031,580.00	395,215,585.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	309,068,200.00	337,119,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	309,068,200.00	337,119,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,400.00	10,578,825.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,400.00	10,578,825.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,281,900.00	23,513,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,281,900.00	23,513,700.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	23,632,080.00	24,003,860.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,632,080.00	24,003,860.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	356,031,580.00	395,215,585.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	356,031,580.00	395,215,585.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,031,580.00	394,715,585.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,924,737.60	258,760,300.00
210101	Үндсэн цалин	160,180,337.60	175,217,265.00

210102	Нэмэгдэл	50,022,400.00	63,662,229.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	5,544,000.00
210104	Урамшуулал	12,178,000.00	14,336,805.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,541,644.00	34,797,600.00
210201	Тэтгэврийн даатгал	19,459,844.00	24,487,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,270,400.00	2,577,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,816,400.00	2,496,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	454,100.00	476,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,540,900.00	4,759,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,387,973.00	22,555,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,590,310.00	1,802,535.00
210302	Түлш, халаалт	19,706,283.00	20,341,000.00
210303	Цэвэр, бохир ус	91,380.00	412,065.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,777,550.00	21,267,500.00
210401	Бичиг хэрэг	2,300,000.00	1,927,900.00
210402	Тээвэр, шатахуун	18,077,550.00	15,105,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,700,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,700,000.00	2,234,300.00
2105	Нормативт зардал	37,297,980.00	35,481,785.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,502,000.00	26,162,935.00
210502	Хоол, хүнс	7,627,280.00	7,606,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,168,700.00	1,712,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,177,000.00	4,958,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,218,900.00	4,069,204.00
210604	Урсгал засвар	958,100.00	888,896.00
2107	Томилолт, зочны зардал	1,800,000.00	1,666,000.00
210702	Дотоод албан томилолт	1,800,000.00	1,666,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,155,495.40	9,402,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,657,495.40	8,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	183,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	298,000.00	764,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,969,200.00	5,825,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,969,200.00	5,825,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ /ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	79,937,380.91	381,957,920.17
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	79,937,380.91	381,957,920.17
Тайлант үеийн үр дүн	-	-	(13,122,791.85)	(13,122,791.85)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	66,814,589.06	368,835,128.32
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	66,814,589.06	368,835,128.32
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	66,814,589.06	368,835,128.32
Тайлант үеийн үр дүн	-	-	-9,557,784.07	-9,557,784.07
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	201,605,647.02	100,414,892.24	57,256,804.99	359,277,344.25

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ЭЗА	Эдийн засгийн ангиллын нэр	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	384,638,200.00	384,636,760.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	384,638,200.00	384,636,760.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	384,638,200.00	384,136,760.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,759,700.00	257,760,300.00
210101	Үндсэн цалин	174,308,400.00	175,217,265.00

210102	Нэмэгдэл	60,778,800.00	62,662,229.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,544,000.00	5,544,000.00
210104	Урамшуулал	17,128,500.00	14,336,805.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,797,600.00	34,797,600.00
210201	Тэтгэврийн даатгал	24,487,200.00	24,487,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,577,600.00	2,577,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,062,100.00	2,496,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	515,500.00	476,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,155,200.00	4,759,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,555,600.00	22,555,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,643,900.00	1,802,535.00
210302	Түлш, халаалт	20,341,000.00	20,341,000.00
210303	Цэвэр, бохир ус	570,700.00	412,065.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,159,300.00	21,159,300.00
210401	Бичиг хэрэг	1,927,900.00	1,927,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,997,100.00	14,997,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,234,300.00	2,234,300.00
2105	Нормативт зардал	26,178,600.00	26,011,160.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,465,900.00	16,692,310.00
210502	Хоол, хүнс	8,000,000.00	7,606,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,712,700.00	1,712,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,958,100.00	4,958,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,958,100.00	4,069,204.00
210604	Урсгал засвар	-	888,896.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,666,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,666,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,903,500.00	9,402,900.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,200,000.00	8,200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,100.00	183,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,265,400.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	764,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,825,800.00	5,825,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,825,800.00	5,825,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	384,638,200.00	384,636,760.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	337,119,200.00	337,119,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	337,119,200.00	337,119,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,513,700.00	23,513,700.00
132001	Орон нутгийн төсвөөс	23,513,700.00	23,513,700.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	24,005,300.00	24,003,860.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,005,300.00	24,003,860.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16
620003	Үйлчлэх ажилтан	4	4
620004	Гэрээт ажилтан	1	1

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,578,825.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,578,825.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,578,825.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,000,000.00
210102	Нэмэгдэл	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	108,200.00
210402	Тээвэр, шатахуун	108,200.00
2105	Нормативт зардал	9,470,625.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,470,625.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,578,825.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,578,825.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,578,825.00

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч эмч Н.Мөнхзул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Должинжав хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төв нь “Иргэдийнхээ эрүүл мэндийг дээдэлж, аймгийн түвшинд тэргүүлсэн, ёс зүйтэй, чадварлаг хамт олонтой, үйлчлүүлэгчдэд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлнэ” гэсэн эрхэм зорилго тодорхойлон ажилласан байна.

Үйл ажиллагааны чиглэл нь сумын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээр тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол
-

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төсвийн байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн ч санхүү, бүртгэлийн чиглэлээр шинэчлэгдсэн хууль, журмыг хамруулж баяжуулалт хийгээгүй, түүнчлэн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан тусгайлан боловсруулж батлуулаагүй байна.

Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төвийн 2016-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2020 оны 04 дүгээр сард хяналт шалгалт хэрэгжүүлжээ. Тус хяналт шалгалтаар цалин илүү олгосон, зориулалт бусаар зарцуулсан нийт 1819.0 мянган төгрөгийг холбогдох хариуцагчаар төлүүлэх 4 төлбөрийн акт, цалин хөлс дутуу тооцож олгосон 840.9 мянган төгрөгийг нөхөн олгох 3 төлбөрийн акт тогтоож, актын төлбөрийг 100 хувь барагдуулсан байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөө дунд гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 371377.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3713.8 мянган төгрөгөөр тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 414692.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4146.9 мянган төгрөгөөр тооцсон болно.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9500.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
33	Авлага	127.3	631.1	503.9
35	Бараа материал	18,241.4	24,170.5	5,929.1

39	Үндсэн хөрөнгө	350,679.5	334,745.8	-15,933.8
3	Нийт хөрөнгийн дүн	369,048.2	359,547.4	-9,500.8
4	Нийт өр төлбөр	213.1	270.1	57.0
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	368,835.1	359,277.3	-9557.8
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	369,048.2	359,547.4	-9,500.8

Авлага дансны эцсийн үлдэгдэл дэх 631.1 мянган төгрөг нь цалингаас суутгасан ХХОАТ-ын илүү төлөлтийн тооцоо байна.

Бараа материалын данс оны эхэнд 18241.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 24170.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оноос 5929.1 мянган төгрөгөөр өсчээ.

№	Үзүүлэлт	Дүн
1	Оны эхний үлдэгдэл	18,241.4
2	Нэмэгдсэн	67,692.6
2.1	Худалдан авсан	63,546.2
2.2	Хандиваар	4,146.4
3	Хасагдсан	61,763.5
3.1	Худалдсан, зарцуулсан	61,763.5
4	Эцсийн үлдэгдэл	24,170.5

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 471405.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 9638.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, оны эцэст 481043.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Хүснэгтээр харуулбал: /мян төг/

№	Үзүүлэлт	Дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	471,405.5
2	Нэмэгдсэн	9,638.0
2.1	Худалдан авсан	3,865.0
2.2	Хандиваар	4,523.0
2.5	Бусад	1,250.0
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	481,043.5
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	120,725.9
801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	25,571.8
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	146,297.7
11	Үлдэгдэл өртөг	334,745.8

Тайланд онд нийт 5773.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэснийг дэлгэрэнгүй харуулбал:

- Эрүүл мэндийн газраас 3800.0 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж,
- Иргэн Ш.Мягмарсүрэнгээс 723.0 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн хөрөнгө
- Аймгийн төрийн сангаас 1250.0 мянган төгрөгийн санхүүгийн программ

Биет бус хөрөнгөд 1250.0 мянган төгрөгийн өртөгтэй программ хангамж, 14080.0 мянган төгрөгийн үнэлгээтэй газар бүртгэлтэй байна.

Өр төлбөр дансны оны эцсийн үлдэгдэл 270.1 мянган төгрөг нь цалингаас суутгасан үйлдвэрчний эвлэлийн өглөг байна.

Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл оны эхэнд 201605.6 мянган төгрөг байсан ба тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 46881.2 мянган төгрөгөөр буюу 13 хувиар өссөн байна. / төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	358,253.8	405,135.0	46,881.2
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,222.2	9,919.4	7,697.2
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	309,068.2	337,119.2	28,051.0
Нэмэлт санхүүжилтийн орлого	49.4	10,578.8	10,529.4
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,281.9	23,513.7	231.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,632.1	24,003.9	371.8

Өмнөх оны үзүүлэлтээс орлого материаллаг хэмжээгээр нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд үнэ төлбөргүй 9919.4 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авсан, түүнчлэн тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт өмнөх оноос 28051.0 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 10529.4 мянган төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөө үзүүлжээ.

Нийт зардал өмнөх оноос 43315.1 мянган төгрөгөөр буюу 11.7%-аар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад материаллаг өөрчлөлтөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл 45078.8 мянга, номативт /хоол хүнс/-ний зардал 4250.9 мянган төгрөгөөр тус тус өссөн нь ихээхэн нөлөө үзүүлжээ.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	371,377.6	414,692.7	43,315.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,235.7	267,598.5	40,362.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх	28,982.5	33,698.6	4,716.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол	21,388.0	22,592.5	1,204.5
2104	Хангамж, бараа материалын зардал	27,768.3	23,560.9	(4,207.4)
2105	Нормативт зардал	32,407.3	37,074.0	4,666.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,625.5	2,400.4	(225.1)
2107	Томиллолт, зочны зардал	1,223.0	600.0	(623.0)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	4,659.6	932.1	(3,727.5)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,087.8	26,035.8	948.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	200.0	200.0

Төрийн албан хаагчдын цалингийн ангилал, зэрэглэлийг 2020 оны 01 дүгээр сараас эхлэн мөрдөхөөр тогтоосон Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оны үзүүлэлтээс материаллаг хэмжээгээр нэмэгджээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 355500.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 355500.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 29138.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 384638.2 мянган төгрөгөөр тайлант оны төсөв баталсан нь өмнөх оны үзүүлэлтээс 28282.8 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд: Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал өмнөх оноос 37130.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний

төлбөрийн зардал 4281.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн, эмийн зардал 10036.1 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлт гол нөлөө үзүүлжээ.

Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 384638.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 337119.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 24005.3 мянган төгрөгийн эрүүл мэндийн даатгалын сангаас, 23513.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн төсвөөс санхүүжилт бүрэн авч, эрүүл мэндийн даатгалын сангаас 1.5 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авч, 384636.7 мянган төгрөгийг урсгал зардалд 100 хувь зарцуулжээ.

Хөтөлбөр	Зориулалт	Арга хэмжээ	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
71601	80302	Нэг иргэнд ногдох нормативаар	9,957.1	9,957.1	-
71602	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	350,667.4	350,665.9	(1.5)
71602	80109	ТЗШ-ийн бга-уудын тогтмол зардал	23,513.7	23,513.7	-
71602	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	500.0	500.0	-
ДҮН			384,638.2	384,636.7	(1.5)

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос сорьц тээвэрлэлтийн санхүүжилт 108.2 мянга, Эрүүл мэндийн газраас эмийн санхүүжилт 10470.6 мянга, нийт 10578.8 мянган төгрөгийн эх үүсвэрийг холбогдох хууль, журмын хүрээнд бүрдүүлжээ.

Дээрх эх үүсвэрээс 9531.2 мянган төгрөгийг зориулалтын дагуу эмийн зардалд, 108.2 мянган төгрөгийг сорьц тээвэрлэлтийн зардалд, 939.4 мянган төгрөгийг цалингийн зардалд зарцуулжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс 2 мэдээллийн хугацаа болоогүй, 17 мэдээллийг хугацаа хоцроож, 140 мэдээллийг хугацаанд нь оруулсан харагдаж байгаа боловч цахим хуудсанд оруулсан ихэнх мэдээллийн иж бүрэн байдал нь хангалтгүй байна. Тухайлбал: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, аудитын дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, аудитын дүгнэлт, тайлан, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл зэрэг мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бичигдсэн 240.0 мянган төгрөгийн актыг 100 хувь бүрэн барагдуулж, 45577.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг 50 хувьтай биелүүлжээ.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, хэрэгжилт

/мянган.төг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	240.0	1	240.0	0		100%
Зөвлөмж	4	45577.1	2	22788.5	2	22788.5	50%
Нийт дүн	5	45817.1	3	23028.5	2	22788.5	75%

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 28534.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1737.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 26796.5 мянган төгрөгийн 3 зөрчлийг таслан зогсоох албан шаардлага, хойшид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд НДШ-ийн өглөг 487.7 мянган төгрөгөөр илүү
2. Санхүүгийн байдал, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 1250.0 мянган төгрөгийн программ хангамжийн ангилал буруу бүртгэсэн

Нийт 1737.7 мянган төгрөгийн бүртгэлийн алдаа, зөрчилд залруулга хийв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Дараах алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны төсвөөс эмнэлгийн ажилтнуудын хоол хүнсэнд 668 кг мах буюу 4008.0 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу “төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУ-ын ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан төлбөрийн акт тогтоох, албан шаардлага өгөх журмын 4.2.1.6, 4.2.1.10 дахь заалтын дагуу албан шаардлага өгөх

Дараах алдаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байдал хангалтгүй, түүнчлэн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээ, байгууллагын батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, бусад мэдээллийг бүрэн байршуулж мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ.”, ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага бичих

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Эд хөрөнгийн тооллогын баримт бичгийг аудитын хугацаанд ирүүлээгүй учир дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, зарцуулалт, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн байна.

1.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй, гэсэн заалттай нийцүүлж төсвийг бодитой төлөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зохих зардлын эдийн засгийн ангиллаас зарцуулж, үнэн зөв тайлагнах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

2.1. Илрүүлэлт: Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн ч санхүү, бүртгэлийн чиглэлээр шинэчлэгдсэн хууль, журмыг хамруулж баяжуулалт хийгээгүй, түүнчлэн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан тусгайлан боловсруулж батлуулаагүй байна.

2.2. Эрсдэл: НББ-ийн хууль зөрчигдөх, бодлого, удирдлага тодорхой бус байх эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн шинэчлэгдсэн хууль эрхзүйн акт, стандартад нийцүүлэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулж мөрдөх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ХОА-2021/74/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрдэнэбүрэн сумын эрүүл мэндийн төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны төсвөөс эмнэлгийн ажилтнуудын хоол хүнсэнд 668 кг мах буюу 4008.0 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан.	4008.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхзул Л.Нямгарав
2	Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй	22788.5	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхзул Л.Нямгарав
3	Төсвийн төлөвлөлтийг оновчтой төлөвлөөгүй, түүнчлэн зарим зардлыг бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахаас гадна бүлэг дотроо зохих бус зардлын эдийн засгийн ангиллаас гүйлгээ хийсэн.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхзул Л.Нямгарав
4	Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн ч санхүү, бүртгэлийн чиглэлээр шинэчлэгдсэн хууль, журмыг хамруулж баяжуулалт хийгээгүй, түүнчлэн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан тусгайлан боловсруулж батлуулаагүй.	-	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхзул Л.Нямгарав
5	Санхүүгийн байдлын тайланд НДШ-ийн өглөг 487.7 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн	487.7	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхзул Л.Нямгарав
6	Санхүүгийн байдал, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 1250.0 мянган төгөгийн программ хангамжийн ангилал буруу бүртгэсэн	1250.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхзул Л.Нямгарав
7	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй		Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Н.Мөнхзул Л.Нямгарав
дүн		28534.2			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР